

**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ АВТОТЭЭВРИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН
ГАЗРЫН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

2025 оны 07 сарын 07

Улаанбаатар хот

Нэг. Хяналт шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Зам, тээврийн яамны Автотээврийн бодлого, зохицуулалтын газар /АТБЗГ/-ын хяналт шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт шинжилгээ хийх журам”, “Үнэлгээ хийх журам”, “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

ЗТЯ-ны АТБЗГ-ын 2025 оны үйл ажиллагааг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, Сайдын тушаалын биелэлт, ТНБД-ын тушаалын биелэлт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр 81.96%-тай байна. /Хүснэгт № 1/

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. АТБЗГ-ын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт	Үүнээс							Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%	Хугацаа болоогүй	
55	21	7	14	6	7	0	-	76.7%

2.2. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт дараах байдалтай байна.

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин					Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”			
4	3	0	1	0	-		89.75%

2.3. Монгол Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт дараах байдалтай байна.

Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин					Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	85 хувь буюу түүнээс дээш “үр дүнтэй”	60-84 хувь буюу “үр дүн хүлээгдэж байгаа”	30-59 хувь буюу “үр дүн хангалтгүй”	0-29 хувь буюу “үр дүн гараагүй”			
1	1	-	-	-	-		100%

2.4. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн явцыг дүгнэвэл

	Хэрэгжилтийн явц зорилтот түвшин	Биелэлтийн хувь
--	----------------------------------	-----------------

Арга хэмжээний тоо	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	
40	30	10	2	78.9%

2.5. Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт дараах байдалтай байна.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0		
7	5	0	0	0	2	0	0	80%

2.6. Сайдын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
21	13	6	2	-	68.42%

2.7. Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт:

Нийт заалт	Үүнээс				Биелэлтийн хувь
	Хэрэгжсэн	Хэрэгжээгүй	Хугацаа болоогүй	Хүчингүй болсон	
17	12	3	2	-	80.0%

Гурав: Үнэлэлт, дүгнэлт

1.Төлөвлөлтийн байдал:

АТБЗГ нь 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа дараах байдлаар төлөвлөсөн байна. Үүнд:Яамны төлөвлөгөөний 2.1.4-д туссан арга хэмжээг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.2-т бүрэн тусгаагүй, яамны төлөвлөгөөний 2.2.1-т туссан арга хэмжээний “зорилтот түвшин”-г газрын төлөвлөгөөний 4.2-т зөрүүтэй төлөвлөсөн, яамны төлөвлөгөөний 2.2.2-т туссан “Автотээврийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэнэ” арга хэмжээний “бүртгэлийн үйлчилгээний хэрэгжилт”, “ажлын гүйцэтгэл” гэсэн шалгуур үзүүлэлтийг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.3-т “тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээг сум, орон нутагт хүргэх ажлыг эхлүүлнэ” хэмээн төлөвлөж “зорилтот түвшин” хэсэгт 1, 2 дугаар улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн, яамны төлөвлөгөөний 2.2.3-т туссан арга хэмжээний эхний хагас жилд “хүрэх түвшин”-г Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4.4 дэх хэсэгт 1 дүгээр улиралд багтаан хийхээр төлөвлөсөн, Яамны төлөвлөгөөний 2.2.6-д заасан “Зам, тээврийн ослын бүртгэл, мэдээллийн платформ”-ыг ашиглалтад оруулах арга хэмжээг Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаагүй байна. Мөн АТБЗГ-ын төлөвлөгөөний 3.1, 3.2, 3.3, 3.4, 6.4 дэх арга хэмжээ нь Автотээврийн салбарын дүрэм, журам, стандартыг эрх зүйн орчинг боловсронгуй болгох арга хэмжээг “зорилтот түвшин”-д тусгаж, эдгээр үйл ажиллагааг зохион байгуулах арга хэмжээг үндсэн зорилт, арга хэмжээ болгон төлөвлөсөн, 4.1 арга хэмжээ болох “Техникийн хяналтын үзлэгийн төвүүдийг тохирлын үнэлгээнд хамруулна” гэсэн үйл ажиллагааны “Техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн 50 хувийг тохирлын үнэлгээнд хамруулах” арга хэмжээг холбогдох эрх зүйн баримт бичигт нийцүүлж төлөвлөөгүй байна.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 68 арга хэмжээний 36 буюу нийт ажлын 52.9%-ийг нь жилийн турш, 20 арга хэмжээ буюу 29.4%-ийг эхний хагас жилд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөсөн байна.

2.Хэрэгжилтийн байдал:

1)АТБЗГ-ын 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайланг нэгтгэхэд Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Засгийн газрын хөтөлбөрийн хэрэгжилт, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, Нийслэлийн Засаг даргатай байгуулсан гэрээний биелэлт, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, Сайдын тушаалын

хэрэгжилт, Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт гэсэн 7 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **81.96%**-тай байна. Эдгээрээс Сайдын тушаалын хэрэгжилт хамгийн бага буюу 68.42%, Газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 76.7%-тай байна.

3) Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг зорилтуудаар нь авч үзвэл:

№	Зорилтууд	Арга хэмжээ	Хэрэгжилт
1	Зорилт 1. Ачаа, зорчигч тээврийн тасралтгүй хэвийн байдлыг хангах, тээвэрлэлтийг нэмэгдүүлнэ. Ачаа, зорчигч тээврийн терминал, автобуудал байгуулах, авто зам дагуух үйлчилгээний цогцолбор байгуулна.	16	86.25%
2	Зорилт 2. Автотээврийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгоно.	11	65.45%
3	Зорилт 3. Автотээврийн хэрэгслээс үүдэлтэй агаар, орчны бохирдлыг бууруулна.	12	68.33%
4	Зорилт 4. Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналтыг сайжруулна.	5	60%
5	Зорилт 5. Салбарын хүний нөөцийг хөгжүүлнэ.	2	100%
6	Зорилт 6. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулна.	9	88.9%

4) Автотээврээр 2025 оны 2 улирлын байдлаар, өссөн дүнгээр 34.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.0%-аар буурсан, 66.9 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.5%-аар өссөн үзүүлэлттэй байна.

5) АТБЗГ-ын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний I улирлын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийн өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд үнэлгээ хийхэд гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 64.2%-тай байсан бол хоёрдугаар улирлын байдлаар 76.7% болж, өмнөх улирлаас 19.5 хувиар өссөн дүнтэй байгаа бөгөөд дор дурдсан зорилтын хүрээний биелэлтэд илүү ахиц гарсан байна. Үүнд:

- *“Автотээврийн хэрэгслийн техникийн байдалд тавих хяналтыг сайжруулах”* зорилтын хэрэгжилт 16 хувиар;
- *“Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах бодлого, хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтийг зохион байгуулах”* зорилтын хэрэгжилт 49 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

6) Дараах зөвлөмжүүд хэрэгжээгүй, удаашралтай хэвээр байна. Үүнд:

- Зам, тээврийн сайдын 2025 оны А/03 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Улс хооронд байнгын ачаа тээврийн “С” төрлийн зорчих зөвшөөрлийн бичиг олгох, ашиглах, хяналт тавих, үйл ажиллагаанд баримтлах удирдамж”-ийн 3.1.2-т заасны дагуу “зөвшөөрлийн бичиг олгох үйл ажиллагаанд бүрэн хяналт тавих, хөндлөнгийн хяналтын зөвлөл”-ийг байгуулж ажиллах;

- Дотоодын ачаа тээврийн үйлчилгээг бүртгэлжүүлэх ажлыг эрчимжүүлэх, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.5.2 дахь заалттай уялдуулан ажиллаж хэрэгжилтийг бүрэн хангах;

- Дорноговь аймгийн Замын-Үүд сумын зорчигч тээврийн авто буудлын барилгын ажлыг эхлүүлэх чиглэлээр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг төлөвлөсөн хугацаанд бүрэн хангах;

- Автотээврийн тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, батлуулах ажлыг эрчимжүүлэх;

- Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.4-т заасан “Нийтийн зорчигч тээвэр, улс хоорондын ачаа тээврийн EURO IV-V стандартын шаардлага хангасан тээврийн хэрэгслийг гаалийн болон НӨАТ-аас чөлөөлөх эрх зүйн зохицуулалтыг бий болгоно” гэсэн арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангах, “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 5.5.2 дахь заалттай уялдуулан хэрэгжилтийг хангах;

- “Автотээврийн хэрэгслийн мэргэшсэн жолооч бэлтгэх, шалгалт авах, үнэмлэх олгох журам”-ыг боловсруулж батлуулах арга хэмжээг эрчимжүүлэх;

- “Техникийн хяналтын үзлэгийн төвүүдийг тохирлын үнэлгээнд хамруулна” арга хэмжээ нь Техникийн хяналтын байгууллагын итгэмжлэлийн хөтөлбөрт тавигдах

шаардлагын ISO/IEC 17020 “Тохирлын үнэлгээ. Хяналтын ажил эрхэлдэг төрөл бүрийн байгууллагын ажиллагаанд тавих шаардлага” стандартын дагуу Үндэсний итгэмжлэлийн төв зохион байгуулдаг тус байгууллагатай хамтран зохион байгуулж 2025 оны эхний хагас жилээр “зорилтот түвшин”-д хүргэх;

-“Тээврийн хэрэгслийн бүртгэлийн үйлчилгээг сум, орон нутагт хүргэх ажлыг эхлүүлнэ” гэсэн арга хэмжээ нь “зорилтот түвшин” хэсгийн “Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх улсын дугаар олгох журам”-д нэмэлт өөрчлөлт оруулсанаар зохион байгуулах тул төлөвлөлтийг эргэж харах;

-Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID) нэвтрүүлэх хүрээнд авто замаас төлбөр авах үйл ажиллагааг цахимжуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах арга хэмжээний “зорилтот түвшин”-д эхний улиралд “Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газартай хамтран төлбөр авах 25 цэгийг цахимжуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулна” гэж туссан тул хэрэгжилтийг эрчимжүүлэх;

- Яамны 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2.1.4, 2.2.2, 2.2.3, 2.2.6-д туссан арга хэмжээний шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинтэй нийцүүлэн эдгээр арга хэмжээг зохион байгуулж, хэрэгжилтийг үнэн зөв тайлагнах;

-АТБЗГ-ын 2025 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 3.1, 3.2, 3.3, 3.4, 6.4-т туссан арга хэмжээний “зорилтот түвшин” нь автотээврийн салбарын эрх зүйн орчинг боловсронгуй болгох ажлын хүрээнд УИХ-ын тогтоол, Засгийн газрын тогтоол, Стандартын техникийн хороогоор хэлэлцүүлэн, дэмжүүлж батлуулахаар төлөвлөсөн байх тул хэрэгжилтийг хангах үйл ажиллагааг зөв зохион байгуулж, эрчимжүүлэх;

Дөрөв. Санал, зөвлөмж

АТБЗГ-ын 2025 оны үйл ажиллагааны эхний хагас жилийн байдлаар хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, дараах санал, зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

4.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 2025 оны эхний хагас жилийн биелэлт дэх хэрэгжилт хангалтгүй, удаашралтай арга хэмжээний хэрэгжилтийг бүрэн хангаж, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэн, улс хоорондын байнгын ачаа, зорчигч тээвэр, дотоодын ачаа, зорчигч тээвэрлэлтийн үйл ажиллагаа болон техникийн хяналтын үзлэгийн тогтолцоог сайжруулан, аюулгүй байдлыг бүрэн хангах чиглэлээр эрх зүйн орчин, удирдлага зохион байгуулалтыг боловсронгуй болгон ажиллах;

4.2. Бүтцийн өөрчлөлт хийгдсэн, Хяналт-шинжилгээ, үнэлгээний журамд өөрчлөлт орсонтой холбогдуулан Гүйцэтгэлийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулахдаа арга хэмжээний суурь болон зорилтот түвшинг тоо, хувиар илэрхийлж болохуйцаар шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, улирал бүрээр хүрэх боломжтой, бодитойгоор төлөвлөх.

4.3. Шинээр батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээний журам”-ын дагуу Бодлогын баримт бичиг, Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг үнэлэх аргачлалд өөрчлөлт орж, тайлагнах хугацаа, биелэлтийн явцаар Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэж байгаа тул Дээд газрын үүрэг даалгавар, шийдвэрийн хэрэгжилтийг тухай бүр чанартай, үнэн зөв, бүрэн тайлагнах;

4.4. Мөн Сайд, Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллах, Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд ажилласан тохиололд холбогдох хууль тогтоомжид заасны дагуу, Гадаад, дотоод томилолтоор ажилласан тохиолдолд холбогдох журамд заасан хугацаанд ГХХАХ-т тайлагнаж хэвших, биелэлтийг дутуу тайлагнасан, арга хэмжээ бүрэн хэрэгжсэн ч хяналтаас хасагдаагүй байгаа зэрэг арга хэмжээнүүдийг Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газартай зөвшилцөж, хяналтаас хасуулан ажиллахыг тус тус зөвлөж байна.